МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 29 өдөр Дугаар А/125 Мөрөн сум

Төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.6, 65 дугаар зүйлийн 65.1.4, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн ээлжит XXIII хуралдааны 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн орон нутгийн хөгжлийн сан дахь "Зураг төсвийн сан"-аас санхүүжүүлэх шинээр барих, засварлах, шинэчлэх барилга байгууламжийн ажлын зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаарыг 1 дүгээр, "ажлын гүйцэтгэл"-ийн төсвөөс санхүүжүүлэх зөвлөх үйлчилгээний төлбөрийн төсөвт өртгийн дээд хязгаарыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Төсөл арга хэмжээний зураг, төсвийг боловсруулах зөвлөх үйлчилгээ нийлүүлэх гүйцэтгэгч сонгож гэрээ байгуулах, хэрэгжилтийг хангах үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг аймгийн Худалдан авах ажиллагааны газар (Б.Должинсорогдог), сумын Засаг дарга, агентлаг байгууллагын удирдлагуудад тус тус үүрэг болгосугай.

3.Төсөл арга хэмжээнүүдийн зураг төсвийн үнийг хавсралтад заагдсан эх үүсвэрээс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Базар), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Оюунтуяа) нарт тус тус даалгасугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Батбилгүүн)-т даалгасугай.

ОРЛОГЧ М.ХУЯГБААТАР

Захирамж2024

6712010411

Аймгийн Засаг даргын 2024 оны
03 дугаар сарын 29-ны өдрийн
А/135 дугаар захирамжийн 1 дүгээр
хавсралт

АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН ДАХЬ "ЗУРАГ ТӨСВИЙН САН"-ААС САНХҮҮЖҮҮЛЭХ ШИНЭЭР БАРИХ, ЗАСВАРЛАХ, ШИНЭЧЛЭХ, БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨРИЙН ТӨСӨВТ ӨРТГИЙН ДЭЭД ХЯЗГААР

№	Арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	тайлбар
1	Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Хүүхдийн 7-р цэцэрлэггийн хүүхдийн яслийн өргөтгөлийн барилгын зураг төсөл боловсруулах	45,000,000	Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна.
2	Хөвсгөл аймаг дах политехник коллежийн 150 хүүхдийн дотуур байрны их засварын ажлын зураг төсөл боловсруулах	8,000,000	Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна
3	Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын хүүхдийн цэцэрлэгийн дээврийн засвар	5000,000	Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна
	Нийт дүн	58,000,000	

Аймгийн Засаг даргын 2024 оны
03 дугаар сарын 29 -ны өдрийн
А/135 ...дугаар захирамжийн 2 дугаар
хавсралт

УЛС, ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ШИНЭЭР БАРИХ, ЗАСВАРЛАХ, ШИНЭЧЛЭХ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН “АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ”-ИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛЭХ ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨСӨВТ ӨРТГИЙН ДЭЭД ХЯЗГААР

№	Арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Тайлбар
1	Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын төвөөс “Бошлой хад” хүртэлх 15км урттай цахилгаан дамжуулах агаарын шугам татах ажлын зураг боловсруулах	20,000,000	Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна
	Нийт дүн	20,000,000	